

АБТС | ХҮНД ХҮРСЭН  
ББСБ | САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ

# ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖИЛИЙН ТАЙЛАН



2024

# АГУУЛГА

## Танилцуулга

## Бизнесийн үйл ажиллагаа

- Бизнесийн зорилго, зээлийн үйл ажиллагаа
- Зах зээлийн мэдээллүүд
- Санхүүгийн үйл ажиллагаа

## Нийгмийн хариуцлага, Байгаль орчны нөлөөлөл

- Үйл ажиллагааны эрсдэл, зорилго, зорилт

## ТУЗ, Гүйцэтгэх удирдлага, компанийн засаглал

- ТУЗ-ийн бүтэц, үйл ажиллагаа
- Засаглалын кодекс
- ТУЗ, Гүйцэтгэх удирдлага түүний шалгуур
- Бусад оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах стратеги

**Mission****Эрхэм зорилго**

"Өөрийн болон хайртай хүмүүсийнхээ амьдралыг сайжруулах чин эрмэлзэлтэй хувь хүмүүст санхүүгийн дэмжлэг, эх үүсвэрээр хангах нь бидний эрхэм зорилго юм.

**Vision****Алсын хараа**

Зорьсон зорилго, мөрөөдөлдөө хүрэхээр хичээнгүйлэн зүтгэж буй хүмүүст санхүүгийн тусламж үзүүлэх. Хүн өөрөө өөрийнхөө амьдралыг сайжруулахад бодит тусламж, зөвлөгөө өгөх.

**Values****Үнэт зүйлс**

Бидний үнэт зүйл бол хүмүүстэй хамтран ажиллахын зэрэгцээ тэдний амьдралыг сайжруулахад нь туслах явдал юм. Үнэт зүйл маань бидний хамгийн том хөдөлгөгч хүч юм.

## “АБТС ББСБ” ТАНИЛЦУУЛГА

Манай байгууллага 2001 онд үүсгэн байгуулагдаж өдгөө 23 дахь жилдээ харилцагчидийнхаа санхүүгийн хэрэгцээ шаардлагыг итгэл төгс ханган ажиллаж байна.

“АБТС” ББСБ нь үүсэн байгуулагдсан цагаасаа үйл ажиллагаандаа ил тод, нээлттэй зарчмыг баримтлан ажилласаар ирлээ. Бизнесийн орчин, харилцагчийн эрэлт хэрэгцээ хурдацтай хувьсан өөрчлөгдөж буй өнөө үед бид харилцагч бүрийн онцлог, хэрэгцээнд тулгуурласан санхүүгийн шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээг зах зээлд тасралтгүй нэвтрүүлж, дээд зэрэглэлийн тав тухтай орчинд, мэргэжлийн түвшний санхүүгийн найдвартай үйлчилгээг үзүүлэхээр ажиллаж байна.

ББСБ 2001 оны 10 дугаар сарын 4-нд Монголбанкнаас зээлийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл авч, үйл ажиллагаа явуулж эхэлсэн билээ. “АБТС” ББСБ нь банкнаас санхүүгийн үйлчилгээ авах боломж хязгаарлагдмал, орлого багатай иргэд, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд эрэлт хэрэгцээнд нь нийцсэн санхүүгийн үйлчилгээ үзүүлж, ажилгүйдлийг бууруулан тогтвортой амьжиргааг нь хангаж, улмаар Монгол улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд тодорхой хувь нэмэр оруулан ажиллаж байна.

Тодорхой зорилготой, тухайн зорилгодоо хүрэх чин эрмэлзэлтэй, хүчин зүтгэх, хөдөлмөрлөх хүсэлтэй хүн бүрт санхүүгийн туслалцаа үзүүлэн дэмжих нь бидний үйл ажиллагааны үндсэн зорилго юм. Бид санхүүгийн зах зээлд шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ нэвтрүүлэх, санхүүгийн үйлчилгээг дэвшилтэт мэдээлэл технологитой уялдуулан хөгжүүлэх, харилцагчдын өсөн нэмэгдэж буй эрэлт хэрэгцээг олон улсын жишигт нийцүүлэн хангахын төлөө үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллаж байна.

2023 оны 10 сарын байдлаар “АБТС” ББСБ нь төслийн болон өөрийн эх үүсвэрээр давхардсан тоогоор нийт 3956 харилцагчдад 70.4 тэрбум төгрөгийн зээл олгосон байна. АБТС ББСБ өнөөдөр олон нийтэд танигдсан, найдвартай санхүүгийн зуучлагч болсон билээ. Манай чадварлаг боловсон хүчин, зохистой удирдлага, хувьцаа эзэмшигчдийн дэмжлэг, нэгдмэл сонирхолтой, тодорхой зорилгод чиглэсэн хамт олны маань хичээл зүтгэл, хөдөлмөр энэхүү амжилтын үндэс болж байгаа бөгөөд цаашдын амжилтад хүргэнэ гэдэгт итгэлтэй байна.

## Бизнесийн зорилго

Манай банк бус санхүүгийн байгууллага дараах зорилго руу чиглэн ажиллаж байна.

- Банкнаас өөрч шаардлагатай санхүүгийн дэмжлэг авч чадахгүй байгаа иргэн, хуулийн этгээдэд санхүүгийн тусламж үзүүлэх
- Ажилгүйдэл, ядуурлыг бууруулахад жижиг, дунд бизнес эрхлэгчдэд туслах
- Шинэ үеийн шилдэг бичил санхүүгийн байгууллагуудын нэг болох.

### Үйлчлүүлэгчид

Бид үйлчлүүлэгчдийнхээ үзэл бодолд ихээхэн анхаарал хандуулж, харилцагчдынхаа бүхий л хэрэгцээг нь хангахын тулд процедурыг хянан үзэх үйлчилгээ үзүүлдэг. Ийм байдлаар бид нөхцөл байдал, хүндрэлтэй үед хүн бүрт туслах зорилготой маш уян хатан бодлогыг сурталчилдаг.

### Зээлийн бүтээгдэхүүн, үйлчилгээ

“АБТС ББСБ” өнөөдрийн байдлаар бизнесийн зээл, автомашины лизингийн зээл, хэрэглээний зээл, орон сууцны зээл, хашаа байшин худалдаж авах, засвар хийх зээл, цалингийн зээл зэрэг нийт 25 төрлийн зээлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хамгийн боломжит хугацаагаар иргэд, ААН-д санал болгож байна. Зээлийн бүтээгдэхүүний онцлог болон хугацаанаас нь хамааран зээлийн сарын хүү 0.7%-3.2% хувийн хэлбэлзэж байна.

### Зээлийн бүтээгдэхүүний төрөл

- Барилгын зээл /төрөл, валют/
- Хүнсний ногооны зээл
- Зоорь агуулахын зээл
- Тээвэр ложистикийн зээл
- Худалдааны зээл
- Гар урлалын зээл
- Жижиг үйлдвэрлэлийн зээлийн шугам
- Орон сууцны зээл
- Орон сууцны нөхцөл сайжруулах зээл
- Хашаа байшин худалдаж авах зээл
- Гэр хорооллын нөхцөл сайжруулах зээл
- Автомашины лизингийн зээл
- Хэрэглээний зээл
- Боловсролыг дэмжих зээл
- Дугаар барьцаалсан
- Мотоциклийн зээл

2024 онд шинээр 3 зээлийн бүтээгдэхүүн харилцагчдын эрэлт хэрэгцээнд тохируулан олгож эхэлсэн ба боловсролыг дэмжих зээл нь онцлох зээл байлаа.

## Зах зээлийн мэдээллүүд

### Монголын макроэдийн засгийн үзүүлэлтүүд

Азийн Хөгжлийн Банк (АХБ)-ны тайланд дурдсанаар Монгол Улсын эдийн засаг 2024 онд 5.5 хувиар өснө гэж тооцоолсон. Энэ нь 2024 оны 4-р сард таамаглаж байснаас нэмэгдсэн үзүүлэлт бөгөөд 4.1 хувь байсан. Харин 2025 оны эдийн засгийн өсөлтийн таамаглалаа 6.0 хувь хэвээр үлдээсэн байна. Эдийн засгийн өсөлтийг үйлчилгээний салбар, аж үйлдвэрийн салбарууд, тэр дундаа уул уурхайн салбарын өсөлт дэмжих төлөвтэй байна. Хөдөө аж ахуйн салбарын энэ оны эхний улирлын огцом уналтаас сэргэж, төсвийн зардал нэмэгдсэнээр ирэх онд эдийн засгийн идэвхжил нэмэгдэх төлөвтэй байна.

Жилийн инфляцийн түвшин 2024 оны 12 дугаар сард улсын хэмжээнд 9.0 хувь, Улаанбаатар хотод 9.1 хувьтай гарсан. Инфляцийн өсөлтөд цахилгаан, мах, импортын барааны үнийн өсөлт голлон нөлөөлсөн байна. Эдийн засгийн сэргэлт, өсөлттэй холбоотой дотоод эрэлт, цалингийн өсөлтийн нөлөөгөөр үйлчилгээ, түрээс, импортын барааны үнэ өндөр өсөлттэй байна. Цаашид төрийн зохицуулалттай үйлчилгээний үнийн өсөлтийн дагасан дам нөлөө, Эрдэнэс Тавантолгой ХК-ийн ногдол ашгийн хуваарилалт, төсвийн зардлын үргэлжилсэн тэлэлт зэрэг хүчин зүйлсийн нөлөөгөөр үнийн өсөлтийн дарамт нэмэгдэх төлөвтэй байгаа нь мөнгөний бодлогын төлөвийг чангаруулах шаардлагыг бий болгож байна.

2025 онд инфляцийн түвшин өмнө төсөөлж байснаас нэмэгдэж 7.2 хувьд хүрэх төлөвтэй байгаа нь дотоодын эрэлт болон төсвийн зардал нэмэгдсэнтэй холбоотой ажээ. Төсөөллийг бууруулж болзошгүй эрсдлүүд нь Бүгд Найрамдах Хятад Ард Улс руу гаргах Монголын түүхий эдийн экспортын эрэлт буурах, Оюутолгой уурхайн олборлолт саарах, геополитикийн хурцадмал байдал болон цаг уурын нөлөөллөөс шалтгаалан бараа бүтээгдэхүүний үнэ буурах болон нийлүүлэлтийн сүлжээ тасалдах зэрэг байна.

Гадаад, дотоод эдийн засгийн өсөлтийн төлөвт томоохон өөрчлөлт гараагүй ч геополитикийн эрсдэл, тодорхой бус байдал буурахгүй үргэлжилсээр байна. Банкны салбарын зээлийн өсөлт өндөр түвшинд хадгалагдаж байгаа нь хэрэглээний импорт, дотоод эрэлтийг өдөөх, цаашлаад санхүүгийн салбарт эрсдэл хуримтлагдахад хүргэж болзошгүй байна.

## Макро эдийн засгийн 2025 оны төсөөлөл

Эдийн засгийн өсөлт 2025 онд уул уурхай, боловсруулах үйлдвэрлэл, хөдөө аж ахуй, үйлчилгээ зэрэг салбаруудын өсөлттэй холбоотойгоор өмнөх оноос эрчимжиж, 8 орчим хувьд хүрэхээр төсөөлж байна. Тухайлбал, Оюутолгойн гүний уурхайгаас олборлох зэсийн баяжмалын үйлдвэрлэл болон баяжмал дахь зэс, алтны агуулга нэмэгдсэнээр уул уурхайн салбар 2025 оны эдийн засгийн өсөлтийн гуравны нэгийг бүрдүүлж, экспортын орлого нэмэгдэн өсөлтийг дэмжих хүлээлттэй байна. Уул уурхайн бус салбарын өсөлтийг 2025 онд 6.7 орчим хувь байхаар төсөөлж байна. Хөдөө аж ахуйн салбарт бодлогын шинэчлэлийг хэрэгжүүлж, өвөлжилт, хаваржилт хэвийн үргэлжлэх нөхцөлд хөдөө аж ахуйн үйлдвэрлэл 2025 онд мөн өсөхөөр байна. Түүнчлэн хувийн секторыг дэмжих замаар хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх бодлого хэрэгжүүлснээр иргэдийн цалингийн орлого сайжран эдийн засгийн дотоод идэвхжилийг хөшүүрэгдэж, худалдаа, үйлчилгээний борлуулалт хадгалагдан, эдийн засгийн өсөлтөд эергээр нөлөөлөх төлөвтэй байна.

## Дэлхийн эдийн засгийн нөхцөл байдал

Сүүлийн жилүүдэд тохиосон цар тахал, геополитикийн тогтворгүй байдал, тэдгээрээс үүдэлтэй тээвэр, логистикийн саатал, үнийн өсөлт болон мөнгөний хатуу бодлогын нөлөө үргэлжилсэн ч ажил эрхлэлт, өрхийн орлогын өсөлт нийт эрэлтийг дэмжсэнээр дэлхийн эдийн засаг 2023 онд 3.3 хувиар өслөө. Дэлхийн эдийн засгийн өсөлт 2024 онд 3.2 хувь, 2025 онд 3.3 хувь орчимд тогтвортой хадгалагдана гэж Олон улсын валютын сан (ОУВС) тооцоолж байна. Дэлхий нийтэд инфляцын түвшин аажмаар буурах хандлага ажиглагдаж байгаа нь мөнгөний бодлогын төлөвийг сулруулах орон зайг бий болгож, эдийн засгийн идэвхжилийг дэмжихээр байна. Гэсэн хэдий ч геополитикийн тогтворгүй нөхцөл байдал хурцдах, голлох эдийн засгуудын өсөлт удаашрах, инфляц төсөөллөөс удаан хугацаанд өндөр түвшинд хадгалагдах зэрэг эрсдэлүүд дэлхийн эдийн засгийн төлөвийг муутгаж болзошгүй хэвээр байна.

Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны 2024 оны 3 дугаар сарын 14, 15-ны өдрийн ээлжит хурлаар эдийн засаг, банк, санхүүгийн зах зээлийн өнөөгийн байдал, гадаад орчны эрсдэлийг харгалзан үзээд:

Бодлогын хүүг 1 нэгж хувиар бууруулж, 12 хувьд хүргэх,

Малчны эргэн төлөлт нь доголдсон зээлд бүтцийн өөрчлөлт хийж, хугацааг сунгах боломжийг банкуудад олгох шийдвэрийг тус тус гаргалаа.

Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны 2024 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн ээлжит бус хурлаар эдийн засаг, банк, санхүүгийн зах зээлийн өнөөгийн байдал, гадаад, дотоод орчны төлөвийг харгалзан үзээд бодлогын хүүг 1 нэгж хувиар бууруулж, 11 хувьд хүргэх шийдвэр гаргалаа.

### Салбарын үзүүлэлтүүд

2024 оны 3 дугаар улиралд СЗХ-оос олгосон тусгай зөвшөөрөлтэйгөөр 555 банк бус санхүүгийн байгууллага (ББСБ) үйл ажиллагаа явуулсан бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6.5 хувиар өссөн байна.

Тайлант улиралд ББСБ-уудын нийт хөрөнгийн хэмжээ 6.4 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 2,160.2 тэрбум төгрөгөөр буюу 50.7 хувиар, 2020 оны 3 дугаар улирлаас 3.3 дахин өсжээ. Нийт харилцагчдын тоо 4,932,618 болж өмнөх оны мөн үеэс 19.1 хувиар нэмэгджээ.

Мөнгөний нийлүүлэлт 2024 оны арванхоёрдугаар сарын эцэст урьдчилсан гүйцэтгэлээр 43.3 их наяд төгрөг болж, өмнөх оноос 5.7 их наяд төгрөгөөр өсжээ. Энэхүү өсөлтөд төгрөгийн хадгаламж 4.9 их наяд төгрөгөөр, төгрөгийн харилцах 1.8 их наяд төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн талаар Үндэсний статистикийн хорооноос мэдээллээ.

Төгрөгийн хадгаламж 2024 оны арванхоёрдугаар сарын эцэст 22.1 их наяд төгрөг болж, өмнөх сараас 989.1 тэрбум төгрөгөөр, өмнөх оноос 4.9 их наяд төгрөгөөр өсжээ. Төгрөгийн хадгаламжийн 19.0 их наяд төгрөг нь иргэдийн хадгаламж, 3.1 их наяд төгрөг нь аж ахуйн нэгж, байгууллагын хадгаламж байна. Харин валютын хадгаламж 4.9 их наяд төгрөг болж, өмнөх сараас 325.1 тэрбум төгрөгөөр өсөж, өмнөх оноос тэрбум төгрөгөөр буурсан байна. Түүнчлэн, чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл 2024 оны арванхоёрдугаар сарын эцэст 1.9 их наяд төгрөг болж, өмнөх сараас 200.3 тэрбум төгрөг буюу 9.7 хувиар, өмнөх оноос 172.6 тэрбум төгрөг буюу 8.4 хувиар тус тус буурчээ.

Салбарын нийт харилцагчдын 94.7 хувь нь финтек харилцагчид, нийт зээлдэгчдийн 78.1 хувь финтек зээлийн үйлчилгээнд хамрагджээ. Финтек зээлдэгчдийн 38.5 хувь нь зөвхөн гар утсаараа дамжуулан зээл авсан байна. Санхүүгийн үйлчилгээнд технологийн дэвшил ашиглаж буй ББСБ-уудын зээлийн үлдэгдлийн 90.9 хувь нь хэвийн, 3.7 хувь нь хугацаа хэтэрсэн, 5.4 хувь нь чанаргүй зээлийн ангилалд байна.

Зөвхөн технологид суурилсан зээл олгодог 5 ББСБ-ын хувьд салбарын зээлдэгчдийн 38.5 хувийг эзэлж байна. Зээлийн үлдэгдлийн 5.9 хувийг эзэлж байгаа нь эдгээр ББСБ-ын зээлийн эргэлт сайтай байгааг илтгэж байна. Мөн 12 нэр төрлийн ногоон зээлийг 6,386 зээлдэгчид олгосон нь нийт зээлийн үлдэгдлийн 2.4 хувь буюу 126.4 тэрбум төгрөг байна.



### Санхүүгийн үйл ажиллагаа

АБТС ББСБ нь 19,718,378,504.19 төгрөгийн хөрөнгөтэй, 12,345,427,441.75 төгрөгийн зээлийн багцтай байгаагаас чанаргүй зээлийн багц 183,031,563 төгрөг байна.

Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон өөрийн хөрөнгө нийт активын харьцаа 20%-иас доошгүй байх шаардлага тавьдаг бол 2023 онд манай байгууллагын зохист харьцаа 27.03% байсан бол 29.7% -иар шаардлага хангасан ба зохист харьцааны бүхий л шалгуурийг хангалаа.

График 1. Нийт зээл, нийт хөрөнгө (сая.төгрөг)





График 2. Чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь



Санхүүгийн үзүүлэлт

График 3. Нийт хөрөнгө, өөрийн хөрөнгө (сая. төгрөг)





График 4. Зээлдэгчдийн төрлөөр



## НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА, БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛӨЛ

### Мод тарих өдөр

Манай байгууллага нь жил бүр уламжлал болгон мод тарих өдрийг хамт олныхоо хүрээнд зохион байгуулдаг. Тус 2024 онд мод тарих өдрийг зохион байгуулсан бөгөөд нэг өдрийг цэвэр агаарт тэмдэглэлт өдөр болгон өнгөрүүлсэн.

### Хог хаягдалын менежмент

Бид Зээлийн судалгаанд шаардагдах зарим материалыг заавал цаасан хэлбэрээр бус цахим платформуудыг ашиглан харилцагчдаас авч байна. Мөн ашиглагдсан боловч дахин ашиглах боломжтой цаасан материалыг дахин ашигласнаар цаасан хаягдлыг тодорхой хэмжээгээр бууруулах боломжийг олгодог

Цаасан хэлбэрээс цахим хэлбэрт шилжсэнээр нь нэг харилцагчтай хийх уулзалтын хугацаа болон хэрэгцээгүй их хэмжээний цаасан хаягдал гарахаас маш сайн сэргийлж байна. Бид цаашид тус зорилтын хүрээнд цахимаар зээл судлах зээлийн апп-тай болох зэрэг байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийг бууруулахаар хичээнгүйлэн ажиллаж байна.

Мөн төрийн байгууллагаас цахим хэлбэрээр олгох боломжтой материалуудыг цаасан хэлбэрээр бус цахимаар авч ашиглах нь маш үр дүнтэй байна.

### Боловсролыг дэмжих ажлын хүрээнд

Боловсролыг дэмжих ажлын хүрээнд ЕБС-ийн суралцагчид хүссэн сургуульдаа суралцах боломж олгох зорилгоор бага хүүтэй зээлийн бүтээгдэхүүнийг нэвтрүүлэн ажиллаж байгаа ба тус сургуульдаа үргэлжлүүлэн суралцах хүсэлтэй ч төлбөрийн боломжгүй байгаа сурагчдын эцэг эхчүүдэд санхүүгийн дарамтнаас сэргийлэх чухал ач холбогдолтой ажил болсон. Цаашид тухайн зээлийн бүтээгдэхүүнийг үргэлжлүүлэх талаар ББСБ-ийн түвшид олон талаас судалж байна.

Боловсролыг дэмжих зээл нь эцэг эхчүүдийн талархлыг хүлээж харилцагчдын өрхийн санхүүд бодит дэмжлэг болж байна.

## Үйл ажиллагааны эрсдэл, зорилго, зорилт

### Үйл ажиллагааны эрсдэл

ББСБ-ийн үйл ажиллагаанд саад учруулж болзошгүй хэд хэдэн хүчин зүйлүүд байна.

Нийгмийн хувьд: Олон улсад хөдөлмөрлөх хүсэлтэй иргэд жил ирэх тусам буурч байгаа байдал ба ажиллах боловсон хүчний асуудал. Энэ асуудал мөн адил манай улсад ажиглагдаж байна.

Байгаль орчин: Хүний үйл ажиллагаанаас шалтгаалахгүй байгалийн гамшиг нь эдийн засгийн салбарт хүндрэл учруулах боломжтой. Тэр тундаа санхүүгийн хохирол ихээр үүсгэсэн гамшиг. Үүний тод жишээ нь Улаанбаатар хотод болсон үерийн асуудал юм.

Хууль эрх зүй: Хууль тогтоох байгууллагын гаргасан зарим шийдвэрүүд нь салбарын үйл ажиллагаанд тодорхой хэмжээнд шууд болон дам байдлаар нөлөөлөх боломжтой.

Эдийн засаг: Санхүүгийн зах зээлийн хэлбэлзэл, олон улсын тогтворгүй байдал.

Макро эдийн засаг: Хүүгийн хувь хэмжээ, мөнгөний бодлого, инфляцийн түвшин.

Өрсөлдөөн: Санхүүгийн зах зээлийн өрсөлдөөн, шинэ өрсөлдөгчид, зах зээлийн хувьсал зэрэг.

Эрүүл мэнд: Ковид 19 цар тахал нь дэлхийн эдийн засаг, байгаль, нийгэм гээд бүхийл салбарт томоохон хэмжээний өөрчлөлт авчирсантай мөн адил дараа дараагийн цар тахал дэгдэх эрсдэл байгааг эрүүл мэндийн байгууллагууд мэдээллэсээр байна. Цар тахал нь санхүүгийн зээлийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудад маш хүнд сорилт болдог.

Эдгээр болон бусад хүчин зүйлүүд үйл ажиллагаанд эрсдэл дагуулж болох ч бид эрсдэлийн урьдчилан харж түүнтэй хэрхэн зохицох, арга хэмжээ авч ажиллах төлөвлөгөөг боловсруулан ажиллаж байна.


Зорилго зорилт: Бид 2024 онд тавьсан зорилтууддаа хүрхээр хичээнгүйлэн ажиллаж томоохон өөрчлөлтүүдийг авчирч чадсаны илрэл нь цар тахлын нөлөөллийг даван туулж чадсан байдал мөн компанийн засаглалд шинэтгэл хийж чадсан явдал байлаа.

Манай байгууллагын томоохон зорилтуудын нэг нь эрсдэлт хурдацтай зөв стратеги баримтлан ажиллах. Хариу үйлдэл хурдан үзүүлэх юм. Ингэснээр тухайн гарч болох хохирол эрсдэлийн хэмжээг байж болох хамгийн бага хэмжээнд барих явдал.

### Компанийн засаглалын кодекс

#### БАЙГУУЛЛАГЫН БҮТЭЦ

АБТС ББСБ нь 8 хувь нийлүүлэгчтэй төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус нийт 5 хүний бүрэлдэхүүнтэй зөвлөл, ТУЗ-ийн дэргэдэх 3 хороо болох Дотоод аудитын хороо, Эрсдэлийн удирдлагын хороо, Засагалал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороогоор удирдуулан Гүйцэтгэх захирал, 5 гишүүн бүхий зээлийн хороо, 4 эдийн засагч, санхүүгийн 2 ажилтан зэрэг бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд хуулийн зөвөлгөө болон аудитын үйлчилгээг Монгол өмгөөлөгч хуулийн фирм, Гэрэлт хөхийн тэнцвэр аудитын байгууллагуудаас аутсорсингийн үйлчилгээ авч ажиллаж байна.



## Төлөөлөн удирдах зөвлөл

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА: ЧИМГЭЭ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮН: АШИДМӨНХ, ЭРДЭНЭЧИМЭГ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮН: БАБА, ТАМИР

Бид Компанийн засаглалыг сайжруулах, засаглалын кодексд нийцүүлэх зорилгоор 2024 онд ТУЗ-ийн гишүүдийн тоог 5 болгох, үүнээс хараат бус гишүүдийн тоог 2 болгох зорилтондоо хүрэн ажиллаж байгаа бөгөөд шинээр 3 хороо байгуулагдсан. Шинээр байгуулагдсан хороод үйл ажиллагаандаа орж 2024 онд нийт 6 ээлжит хурал зохион байгуулж ажилласан байна. Мөн урт хугацааны зорилтын хүрээнд ТУЗ-ийн эмэгтэй гишүүдийн тоог 50% хүргэх, дийлэнх гишүүдийг хараат бус гишүүн байх зорилтын хүрээнд үйл ажиллагаагаа хичээнгүйлэн ажиллаж байна.

ТУЗ	ТУЗ-ийн дарга	Хувьцаа	Хуралдааны ирц
	Чимгээ	8.96%	100%
	ТУЗ-ийн гишүүн		
	Тамир	27.54%	100%
	Бизнес Партнер	41.27%	-
	ТУЗ-ийн хараат бус гишүүн		
	Ашидмөнх	1.18%	100%
	Эрдэнэчимэг	-	60%

## Аудитын тогтолцоо

### Дотоод аудит

“АБТС ББСБ” нь дотоод аудит хариуцсан бүцэт бүрэлдэхүүн байхгүй байгаа боловч компанийн ирээдүйн төлөвлөгөөнд бүтэц бүрэлдэхүүнтэй орон тоотой болохоор төлөвлөж байгаа. Аудитын үйлчилгээг аутсорсингоор мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллаж байна.

2024 оны 6-р сарын 6-ны өдрийн ТУЗ-ийн 13-р тогтоолоор ТУЗ-ийн дэргэдэх Дотоод аудитын хороог байгуулсан. Тус хороо нь үйл ажиллагааны журмын хүрээнд улиралд 1, нийт 2 ээлжит хурал зохион байгуулж ТУЗ-д зөвлөмж хүргүүлэн ажилласан.

Гүйцэтгэх удирдлагын үндсэн цалин, шагнал урамшууллыг олгох гүйцэтгэлийн шалгуур

Тэнцвэржүүлсэн онооны систем буюу КРІ дэх зорилтуудын биелэлтээр Гүйцэтгэх захирлын ажлын гүйцэтгэлийг үнэлж, цалин болон бусад урамшууллыг олгодог. Үнэлгээг нийт 100 онооноос үнэлэх ба 5 үзүүлэлтээр үнэлдэг. Үүнд

Сургалт, мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилтод өгөх үнэлгээ

Хяналтын ажиллагаанд өгөх үнэлгээ

Зорилтын биелэлт буюу үр дүнгийн оноо

Удирдах ажилтны үнэлгээ

Хасагдах үнэлгээ

Гүйцэтгэлийн үнэлгээний биелэлтээр

- Гүйцэтгэл маш сайн, зорилтыг давуулан биелүүлсэн ✓ ГНХ > 90%
- Гүйцэтгэл хангалттай, зорилтыг бүрэн биелүүлсэн ✓ ГНХ > 80%
- Гүйцэтгэл дунд, зорилтын ихэнх хэсгийг биелүүлсэн ✓ ГНХ > 70%
- Гүйцэтгэл сул зорилтыг хэсэгчлэн биелүүлсэн ✓ ГНХ > 60%
- Гүйцэтгэл хангалтгүй, зорилтыг огт биелүүлээгүй ✓ ГНХ > 60%

## КОМПАНИЙН ОРОЛЦОГЧ ТАЛУУДТАЙ ХАРИЛЦАХ, ХАМТРАН АЖИЛЛАХ

### Оролцогч талууд

- Хувьцаа эзэмшигчид
- Ажилтан
- Хэрэглэгч, харилцагч
- Харилцагч байгууллага
- Төрийн байгууллага

2024 онд дээрх оролцогч талуудтай харилцан, хамтран ажилласан ажиллагааг хуульд заасан эрх зүйн хэм хэмжээг болон, ёс зүйн хэм хэмжээг баримталж ажиллаж байна.

Хувьцаа эзэмшигчдийг мэдээ мэдээллээр хангах, хууль тогтоомжид заасан эрхийг хүндэтгэн тэгш хандаж шаардлагатай мэдээ мэдээллээр тухай бүрт нь хангаж, санал хүсэлтийг цахим шуудан, веб хуудас зэргээр идэвхитэй солилцож хамтран ажиллаж байна. Хуульд заасан хугацаанд хурлыг амжилттай зохион байгуулж хамтран ажилласан.

Ажилтан нь үйл ажиллагааг хэрэгжүүлэгч гэдэг утгаар нь харилцахдаа хөдөлмөрийн гэрээ, ажлын байрны тодорхойлолтод заасан эрх хэмжээ, үүрэг хариуцлагын хүрээнд харилцаж ажиллаж байна.

Хэрэглэгч, харилцагчийг компанийн орлогыг бүрдүүлэгч гэсэн утгаар нь тэдний хэрэгцээ чанар, тоон үзүүлэлтээр бүрэн хангах зорилго бүхий байгууллагын соёлыг бүрдүүлж харилцагчдад шаардлагатай мэдээ мэдээлэл, зөвлөгөөгөөр хангаж санал хүсэлтийг тухай бүрт нь шийдвэрлэн ажиллаж байна.

Харилцагч байгууллага компанийн үйл ажиллагааны эх үүсвэрээр хангагч гэсэн утгаар нь гэрээний дагуу хүлээсэн үүргээ бүрэн хэрэгжүүлж ажиллаж байна. Талуудын хууль, гэрээгээр хүлээсэн эрх үүрэг, ёс зүйн хэм хэмжээг эрхэмлэн харилцагч байгууллагатай байнгын уялдаа холбоотой байдаг.

Холбогдох хууль тогтоомжид заасан нөхцөл шаардлагыг бүрэн хангаж, зохицуулагч, төрийн байгууллагад шаардлагатай тайлан, мэдээг цаг тухайд нь хүргүүлэн ажиллаж байна.